

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 04 сарын 17-ны  
өдрийн 3884 дугаарт бүртгэв.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 04 дугаар  
сарын 05 -ны өдөр

Дугаар А/82/128

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Ш.Мягмар/, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сум, дүүргийн Засаг дарга, Сав газрын захиргаадад үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД



Н.ЦЭРЭНБАТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Бүртгэлийн дугаар 407/136

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

УСЫН ДАРГА



Д.Батжаргал

2018 04 12

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Эрүүл мэндийн сайдын хамтарсан  
2018 оны 04 дүгээр сарын 05 -ны өдрийн  
А/82/128 дугаар тушаалын хавсралт

УС АШИГЛАГЧ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА НЬ  
АХУЙН БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ЦЭГЭЭ УС ТУСГААРЛАГЧААР  
ТУСГААРЛАЖ ТОХИЖУУЛАХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь /цаашид "ус ашиглагч" гэх/ ахуйн бохир ус зайлуулах цэгээ /цаашид "цэг" гэх/ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

**Хоёр. Цэгийг тусгаарлаж тохижуулахад тавих шаардлага**

2.1. Ус ашиглагч нь Усны тухай хуульд заасны дагуу хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авна.

2.2. Цэгийн орчны газрыг тэгшилж, хур борооны ус, чийг шүүрч нэвчихээс сэргийлж гадаргын урсац зайлуулах суваг татаж, бохир ус зөөвөрлөх машин чөлөөтэй орж гарах талбайтай байна.

2.3. Хоногт 5 шоо метрээс их ахуйн бохир ус хуримтлагдах цэгийг батлагдсан зураг төслийн дагуу хийнэ.

2.4. Цэгийг бетон, төмөр бетон болон бусад ус үл нэвчих материалаар доторлоно:

2.4.1. бетон, төмөр бетон нь усны барилга, байгууламжийн бүтээцэд тавигдах шаардлагыг хангасан байна;

2.4.2. бусад ус үл нэвчих материалаар доторлосон үед цэгийн бохир ус соруулах хэсэг нь гэмтэхээс хамгаалсан хийцтэй байна.

2.5. Цэгийн хөрсний устай харьцах хэсгийг ус үл нэвчих материалаар хийнэ.

2.6. Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.

2.7. Цэгийн бохир усыг суллах, цэгт халдваргүйжүүлэлт хийхдээ тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

2.8. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь Усны тухай хуульд заасны дагуу бохир ус зайлуулах тогтоосон цэгт болон төвлөрсөн шугам сүлжээний зөвшөөрөлтэй худагт нийлүүлнэ.

2.9. Ус ашиглагч нь дахин ашиглах боломжгүй цэгт халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлт хийлгэж, эрүүл хөрсөөр дүүргэж, цэг болон түүний орчинд халдваргүйжүүлэлтийг давтан хийлгэнэ.

2.10. Сум, дүүргийн Засаг дарга нь цэг, түүний орчинд хөрсний бохирдлын шинжилгээг жилд 1-ээс доошгүй хийлгэж, халдваргүйжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

2.11. Цэгт хатуу хог хаягдал хаяхыг хориглоно.

Цэгийн дугаар 000... 408/156

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН

УСНЫ ДАРГА

18 04 2018 оны 04 сарын 12 өдөр

Х.Тамтсоговал